



IV/2022


Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 15



Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 300.0 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 4 дүгээр сард атны үнэ 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 32.9 мянган төгрөгөөр, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 29.6 мянган төгрөг, хязаалан гуных 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 16.4 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 227.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 9.7 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 160.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 4.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), мянган төгрөгөөр




Эр хонины үнэ 2022 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна. Хөвсгөл аймагт хамгийн бага буюу 176.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 4.0 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 4 дүгээр сард, мянган төгрөг




Цагаан ноолуурын 1 кг-ын үнэ 2022 оны 4 дүгээр сард Дорноговь аймагт хамгийн их буюу 125.0 мянган төгрөг, Хэнтий аймагт хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. ЦАГААН НООЛУУРЫН 1 КГ-ЫН ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 4 дүгээр сард, төгрөгөөр



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 4 дүгээр сард 5.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 500 төгрөгөөр, ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 108.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 25.8 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 дүгээр сард, төгрөгөөр



Хивэгний (25 кг) үнэ 2022 оны 4 дүгээр сард Архангай, Баянхонгор аймагт хамгийн их буюу 25.0 мянган төгрөг, Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 10.0 мянган төгрөг байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2022 оны 6 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын

Үнийн статистикийн хэлтсийн гэрээт

ажилтан Б.Оргил

Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212